



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/174

Улаанбаатар хот

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны
бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1.4 дэх заалт, Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-ын 4.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны удирдлагыг Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга гэж өөрчилсүгэй.

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны зохион байгуулалтын бүтцийг доор дурдсанаар шинэчлэн баталсугай:

- 2.1. Захиргаа, удирдлагын газар;
- 2.2. Бодлого, зохицуулалтын газар;
- 2.3. Мансуурах, согтуурах донтолтоос урьдчилан сэргийлэх газар;
- 2.4. Олон нийттэй харилцах газар.


3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны орон тоог нэгдүгээр, ажил үүргийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

4. Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталж, байгууллагын чиг үүргийг батлагдсан төсөв, орон тоонд багтаан хэрэгжүүлэхийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Ж.Буянбатад үүрэг болгосугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоог батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/173 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.АМАРСАЙХАН



Сайдын 2026 оны тушаал

152610348

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2026 он 4 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ОРОН ТОО /18/**

№	Албан тушаал	Орон тоо
Нэг.Удирдлага		
1.	Ажлын албаны дарга /ТТ-1/	1
Хоёр.Захиргаа, удирдлагын газар		
2.	Газрын дарга /ТТ-2/	1
3.	Ерөнхий нягтлан бодогч /ТҮ-11/	1
4.	Хүний нөөц, гэрээ, эрх зүйн ахлах мэргэжилтэн /ТТ-4/	1
5.	Гадаад хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн /ТҮ-8/	1
6.	Дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн /ТҮ-8/	1
7.	Шуурхай албаны жолооч /ТТ-9/	1
Гурав.Бодлого, зохицуулалтын газар		
8.	Газрын дарга /ТТ-2/	1
9.	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан чиглэлийн ахлах шинжээч /ТТ-3/	1
10.	Салбар зөвлөл хариуцсан ахлах шинжээч /ТТ-4/	1
11.	Хүчирхийлэл, хүн худалдаалахтай тэмцэх асуудал хариуцсан ахлах шинжээч /ТТ-4/	1
12.	Тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх асуудал хариуцсан ахлах шинжээч /ТТ-4/	1
Дөрөв.Мансуурах, согтуурах донтолтоос урьдчилан сэргийлэх газар		
13.	Газрын дарга /ТТ-2/	1
14.	Мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх асуудал хариуцсан ахлах шинжээч /ТТ-4/	1
15.	Архидан согтуурахтай тэмцэх асуудал хариуцсан ахлах шинжээч /ТТ-4/	1
Тав.Олон нийттэй харилцах газар		
16.	Газрын дарга /ТҮ-11/	1
17.	Цахим мониторинг, олон нийттэй харилцах ахлах ажилтан /ТҮ-8/	1
18.	Зураглаач, эвлүүлэгч /ТҮ-7/	1
Нийт		18

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2026 оны 11 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

Нэг. Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга.

- 1.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан уялдуулан зохицуулах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 1.2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам"-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
- 1.3. Зохицуулах зөвлөлийн даргад бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, шаардлагатай мэдээллээр хангах;
- 1.4. Зохицуулах зөвлөлийн даргаас зөвшөөрч, шилжүүлэн олгосон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журмын 4 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
- 1.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого, үйл ажиллагааг улс орон даяар нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлэх, үр дүнд суурилсан удирдлагын арга барилыг нэвтрүүлэх.

Хоёр. Захиргаа, удирдлагын газар

- 2.1. Байгууллагын захиргаа, удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг зохион байгуулах, уялдаа холбоог хангах;
- 2.2. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн хөтлөх, төсөв, санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, хяналтыг хэрэгжүүлэх;
- 2.3. Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, сонгон шалгаруулалт, хөдөлмөрийн харилцааг зохицуулах, гэрээ, хэлцэл боловсруулах, алба хаагчид үйл ажиллагаагаа хуулийн дагуу явуулж байгаа эсэхэд хяналт тавих, тэдэнд эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- 2.3. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллага, түншлэл, төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах, гадаад харилцааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;
- 2.4. Байгууллагын дотоод зохион байгуулалт, бичиг хэрэг, архив, албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааны уялдааг хангах;
- 2.5. Ажлын албаны албан хаагчдын хариуцсан ажил, чиг үүргийн дагуу тайлан мэдээг авч нэгтгэх, холбогдох газарт хүргүүлэх;
- 2.6. Байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай тээврийн хэрэгслийн найдвартай, шуурхай үйлчилгээг үзүүлэх, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал, ашиглалтын аюулгүй байдлыг хангах;
- 2.6. Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргад дэмжлэг үзүүлэх;
- 2.7. Холбогдох хууль, эрх зүйн актад заасан бусад.

Гурав. Бодлого, зохицуулалтын газар.

- 3.1.Холбогдох хуульд заасан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;
- 3.2.Нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах;
- 3.3.Дээд шатны байгууллагаас гаргасан хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;
- 3.4.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд болон салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулж, мэргэжлийн удирдлагаар хангах;
- 3.5.Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүй, зохион байгуулалт, хүмүүжлийн шинж чанартай нийтлэг арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 3.6. Урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг дүгнэх, тайлагнах, сайжруулах санал боловсруулах;
- 3.7.Гэр бүлийн болон бусад хэлбэрийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг хангах;
- 3.8.Нийгэмд түгээмэл болон өсөх хандлагатай тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бодлого, судалгаа, арга хэмжээг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах;
- 3.9.Зохицуулах зөвлөлийн дарга болон Ажлын албаны даргаас өгсөн бусад чиг үүрэг.

Дөрөв.Мансуурах, согтуурах донтолтоос урьдчилан сэргийлэх газар

- 4.1.Мансуурах болон согтуурах донтолтоос урьдчилан сэргийлэх бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн уялдааг хангах, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг зохион байгуулах;
- 4.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр бодлого, судалгаа, арга хэмжээг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог хангах;
- 4.3.Архидан согтуурахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, олон нийтийн оролцоонд суурилсан нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг хангах.
- 4.4.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон архидан согтуурахтай холбоотой гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг бууруулах, эрсдэлт бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах.

Тав.Олон нийттэй харилцах газар.

- 5.1.Олон нийттэй харилцах бодлого, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, байгууллагын мэдээлэл, сурталчилгаа, хэвлэл мэдээллийн ажлын уялдаа холбоог зохион байгуулах;
- 5.2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод хүргэх, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах, олон нийтийн оролцоонд суурилсан харилцаа, мэдээллийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- 5.3.Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл, контент, видео танилцуулга, инфографик бэлтгэж түгээх;

5.4.Улсын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах;

5.5.Олон нийтийн санал, хандлага, мэдээллийн урсгалыг цахим орчинд хянах, дүн шинжилгээ хийх, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг шуурхай, үнэн зөв хүргэх, олон нийттэй харилцах үйл ажиллагааг зохион байгуулах;